

**ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ
ГОНЧИГДОРЖ ОВОГТОЙ ШҮРЭНЧУЛУУНЫ 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин					
		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биел: тийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах							
1	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах" төслийн "Хилийн хяналт удирдлагын систем"-д Гэрийн тэжээвэр амьтан, цацрагийн бүртгэл, халдваргүйжүүлэлт, шарилын бүртгэлийг хорио цээрийн модуль, түр тусгаарлалтын модуль оруулан шаардлагын тодорхойлолт боловсруулан хөгжүүлэлтийг эхлүүлж, төстийн орчинг үүсгэсэн	1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал /хүний хөл хориот өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлс, химийн болон цацрагийн осол, хордлого, хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт /-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны талаар харьяа гаалийн газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар тухай бүр хангаж ажиллана. 6.Амьтан, ургамал, зорчигчийн түр тусгаарлалтын модулыг эцэслэсэн байна.	Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах" төслийн "Хилийн хяналт удирдлагын систем"-д Гэрийн тэжээвэр амьтан, түр тусгаарлалтын модулийн шаардлагын тодорхойлолт боловсруулан хөгжүүлэлтийг хийж дууссан. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэгт заасан амьтны гоц халдварт өвчин болон ургамлын хорио цээртэй хөнөөлт организм улсын хилээр нэвтрэн тархах эрсдэл үүссэн болон үүсч болзошгүй нөхцөл байдал бүрдсэн үед баримтлах нийтлэг журам /дэглэм/-ийг боловсруулан ажиллаж байна. Журмын төсөлд Мал амьтны	2025.01.01 2025.06.10	100

					эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас холбогдох мэргэжилтнийг оролцуулхаар албан бичиг хүргүүлсэн. Хүрсэн үр дүн: Хилийн боомтод амьтан, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн үед авах хариу арга хэмжээ оновчтой, тодорхой болсон.		
2	Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан МУ-ын Засгын газрын 173 тоот тогтоолоор батлагдсан “Жагсаалт, журам батлах тухай” – журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлийн хэсэг байгуулж батлуулж ажиллах.</p> <p>Хэлтсийн “Дотоод ажил үүргийн хуваар”-ийн дагуу Замын-Үүд боомтын хорио цээрийн хяналт шалгалтаар илэрч саатуулсан, хураасан, устгасан, буцаасан бараа, бүтээгдэхүүний мэдээг авч нэгтгэсэн.</p>	<p>1.Улсын хилээр нэвтрүүлж буй хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх ажлыг зохион байгуулах, харьяа газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.</p> <p>2.Хяналт, шалгалтын үйл ажиллагаа, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.</p> <p>3.Мал эмнэлгийн хяналтад хамаарагдаг барааны 2 төрлийн зааврыг эцэслэн боловсруулан, баталгаажуулж, цахимаар ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>10. Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор холбогдох яам, агентлагаас зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллана.</p> <p>11.Батлагдсан төлөвлөгөөний дагуу харьяа гаалийн газар, хороодын улсын байцаагчдад сургалт зохион байгуулна.</p>	<p>Мал эмнэлгийн хяналтын чиглэлээр боловсруулж буй мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импорт, экспортлох үеийн хяналтын хуудас, Тэжээвэр мал, амьтны тэжээл импортлох үеийн хяналтын хуудсуудыг боловсруулан дуусгаж санал авч баталгаажуулхад бэлэн болгосон.</p> <p>Мал эмнэлгийн ерөнхий газраас албан бичгээр ирүүлсэн “Экспортын гэрчилгээ, импортын болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэлд баталгаажуулах тэмдэг, гарын үсгийн баталгаа”-г гаалийн газар, хороодод 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 02-1,2/21712 албан бичгээр хүргүүлж чиглэл өгсөн.</p> <p>Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК-аас ирүүлсэн “Хамтран ажиллах гэрээ”-ний төсөлтэй танилцан холбогдох саналуудыг Хуулийн хэлтэст Дотоод албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2025 оны 05 дугаар сарын 14 ны өдөр ГХЯ-аас зохион байгуулсан “МУ-аас Халал аргаар бэлтгэсэн махны</p>	2025.01.01 2025.06.10	100

					<p>экспортыг нэмэгдүүлэх”- боломж, шийдэл сэдэвт уулзалтад ГХЦХ-ын дарга Г.Батмөнхийн хамт оролцож 2025 онд экспортлогдсон махны статистик болон экспортыг нэмэгдүүлэх шийдлүүдийн талаар санал солилцсон.</p> <p>Хүрсэн үр дүн: Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд хийгдэх хорио цээрийн хяналтын эрх зүйн зохицуулалт тодорхой болсон.</p>		
3	<p>Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл, экспортлогч улсын мал эмнэлэг, ариун цэвэр, ургамлын хорио цээрийн гэрчилгээг үндэслэн импортын гэрчилгээ олгох үйл ажиллагаанд хяналт тавих</p>	<p>Хэрэгжилт, гүйцэтгэлээр</p>	<p>Тайлант хугацаанд /Caps.gaali.mn/ цахим системээр импортын мэдэгдэл, экспортын гэрчилгээ хүссэн давхардсан тоогоор 139 аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.</p> <p>Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан хорио цээрийн хэлтсийн хэрэгжүүлж байсан чиг үүргийг шилжүүлэх ажлийн хэсгийн уулзалтад оролцож тодорхой саналуудыг гаргасан.</p> <p>Мөн МЭЕГ-ын ажил хүлээлцэх ажлийн төлөвлөгөөнд санал хүргүүлж ажилласан.</p>	<p>1.Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдлийг баталгаажуулах үйл ажиллагааны талаар чиглэл, зааврыг хүргүүлж ажиллана.</p> <p>2.Импортын гэрчилгээ олголтыг хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.</p> <p>3.Харьяа гаалийн газар, хороодоос мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд цахимаар олгох "Импортын гэрчилгээ"-г боловсронгуй болгож, хяналт, шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр Мэдээллийн технологийн газартай хамтран ажиллана.</p>	<p>/Caps.gaali.mn/ цахим системээр импортын мэдэгдэл, экспортын гэрчилгээ давхардсан тоогоор 46 хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байна.</p> <p>Гаалийн байгууллагаас олгож буй Импортын гэрчилгээний загварыг шинэчлэн Мал, амьтны болон мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гэсэн 2 төрөлтэй болгохоор эцэслэн боловсруулсан.</p> <p>Боловсруулсан Импортын гэрчилгээний загварыг батлуулхаар ГЕГ-ын даргын тушаалын төслийг боловсруулж бэлэн болгосон.</p> <p>Импортын гэрчилгээний загвар шинэчлэгдэж буйтай холбогдуулан Хорио цээрийн системийн дэд цэсийг шалгаж сайжруулалт боловсруулалтын санал өгч ажилласан.</p> <p>Гаалийн байгууллагаас олгон ажиллаж байсан</p>	<p>2025.01.01 2025.06.10</p>	100

			<p>1281 болон хэлтсийн дотоод утсаар холбогдсон иргэн, аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл хүссэн хүсэлтэд тодорхой мэдээллүүдийг түргэн шуурхай өгч ажилласан.</p> <p>“Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ын 3 заалтад санал өгсөн.</p> <p>ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар болон МЭЕГ-ын хамтарсан мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн импортлохын өмнөх эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэгт ажилласан.</p>		<p>Импортын болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдэл, экспортын гэрчилгээг хуульд заасан байгууллагуудад шилжүүлж буйтай холбогдуулан Гаалийн газар хороодод дотоод албан бичгээр Мэдэгдэл хүргүүлж ажилласан.</p> <p>Хүрсэн үр дүн: Хорио цээрийн цахим системээс Импортын гэрчилгээг олгодог болсноор Харьяа гаалийн газар, хороодын мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавих үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой болсон.</p>		
4	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Хөдөө аж ахуйн биржээс хэрэгжүүлж буй цахим нэг цонхны сиситем/export.mofa.gov.mn/-д гаалийн хорио цээрийн arqs.gaali.mn системийг холбож ААН-ийн экспортод зарцуулах цаг, хугацааг багасгасан.</p> <p>Хорио цээрийн гэрчилгээ, мэдэгдэл олгох цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийх шаардлагуудын талаар 6 ажлын санал</p>	<p>1.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой хууль эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.</p> <p>2. "Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын биелэлт", "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт" зэрэг холбогдох тогтоол,</p>	<p>Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын хавсралт "Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт", "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам", "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам"-ын төслүүдийг боловсруулсан.</p>	2025.01.01 2025.06.10	100

			<p>боловсруулж Мэдээлэл технологийн газарт хүргүүлсэн. Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан хорио цээрийн хэлтсийн мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдын албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулж ажлийн хэсэгт хүргүүлсэн.</p>	<p>шийдвэрийн хорио цээрийн хяналттай холбоотой заалтын тайланг хугацаанд нь гаргана.</p>	<p>Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагаанд ISO 9001:2015 болон ISO 27001:2022 стандартын хэрэгжилтэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын даалгаварт дотоод албан бичгээр хариу хүргүүлсэн. ГЕГ-ын даргын 2025.04.07-ны өдөр баталсан "Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөө"-ний 5. Бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад хуурамч бичиг баримт бүрдүүлсэн тохиолдлыг бүртгэх, сан үүсгэх-д томилогдсон ажиллаж төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэн ажилласан. Хүрсэн үр дүн: Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд хийгдэх хорио цээрийн хяналтын эрх зүйн зохицуулалт тодорхой болсон.</p>		
5	Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд хяналт тавих	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>2024 оны эхний хагас жилд мал эмнэлгийн хяналтаар 842 аж ахуйн нэгжийн 1,6 мян.тн бараанаас 17,5 мян.долларын дүнтэй, 1157 төрлийн, 812,4 кг, 1,6 мян.төгрөгийн барааг лабораторийн шинжилгээнд хамруулж, аюулгүй үзүүлэлтийн шаардлагаар 1402 үзүүлэлтээр, 46 үзүүлэлтээр мал эмнэлгийн хорио цээрийн шаардлага хангасан байна</p>	<p>1.Хяналтын чиглэл бүрээр лабораторийн шинжилгээнд хамрагдсан барааны тоо хэмжээ, үзүүлэлтийн тайланг сар бүр нэгтгэн, удирдлагуудыг мэдээллээр хангаж ажиллана. 2.Лабораторийн шинжилгээгээр эерэг буюу шаардлага хангаагүй гарсан барааны дүнд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, энэ чиглэлээр газар, хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.</p>	<p>Мал эмнэлгийн хяналтын чиглэлээр нийт 1699 аж ахуйн нэгж, 2 иргэн бараа экспортолсноос 1676 мэдүүлгээр, ангилалтын тоо хэмжээгээр 50,981,1тн, 212л, 37 мэдүүлгээр 35064 ширхэг, 6 мэдүүлгээр 4300 толгой, 102400 хос, 3 мэдүүлгээр 1,4 дм² бараа экспортлогдсон байна. Барааны цэвэр жин 35,084.4мян.тн, бохир жин 39,096,4тн, 314,474,3 сая.долларын үнийн дүнтэй байна. Мал эмнэлгийн хяналтын чиглэлээр нийт 868 аж ахуйн</p>	2025.01.01 2025.06.10	100

				<p>нэгж, 8 иргэний бараа импортлогдсоноос 962 мэдүүлгээр цэвэр жингээр 23,638.9 тн, бохир жингээр 24,804.2 тн 797,3 сая.долларын бараа импортлогдсон.</p> <p>Мал эмнэлгийн хяналтаар 226 аж ахуйн нэгж, 24 иргэний 3465,8тн 1646ш, 8 толгой бараанд 731ш экспортын гэрчилгээ олгож, 7.2сая төгрөгийн хураамж, 885 аж ахуйн нэгжийн 18,415.8 тн бараанд 889 импортын гэрчилгээ олгож, 8.870 сая төгрөгийн хураамж, 59 аж ахуйн нэгжийн бараанд 60 импортын мэдэгдэл олгож, 600,0 мянган төгрөгийн хураамжийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. мал эмнэлгийн хяналтаар 749 аж ахуйн нэгжийн 8174,8тн, 48,1 сая.долларын үнийн дүнтэй, 1363 нэр төрлийн бараанаас, 2738кг, 96,2 мян.долларын барааг чанар, аюулгүй байдлын 3172 чанар аюулгүй байдлын үзүүлэлт болон 68 хорио цээрийн үзүүлэлтээр лабораторийн шийнжилгээн хамруулж, 1 дээжийн 1 сорьц эерэг үзүүлэлттэй гарсан байна.</p> <p>Хүрсэн үр дүн: МУ-д импортлогдож буй мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хийгдэж буй лабораторийн шинжилгээт хяналтын үр дүнг баталгаажуулсан.</p>	
--	--	--	--	--	--

Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх

<p align="center">6</p>	<p>Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх</p>	<p align="center">Хэрэгжилт, гүйцэтгэлээр</p>	<p>Аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын “CPV Food” Co.,Ltd, Бүгд Найрамдах Солонгос Улсын “ Narim” Co.,Ltd компануудын тахианы мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үйл ажиллагаанд импортлохын өмнөх эрсдэлийн хянан магадлагааг хийж ажилласан. 1281 болон хэлтсийн дотоод утсаар холбогдсон иргэн, аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл хүссэн хүсэлтэд тодорхой мэдээллүүдийг түргэн шуурхай өгч ажилласан. “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ын 3 заалтад санал өгсөн. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар болон МЭЕГ-ын хамтарсан мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн импортлохын өмнөх эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэгт ажилласан.</p>	<p>1. Хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгох зорилгоор Эрсдэлийн удирдлагын хэлтэстэй хамтран ажиллана. 2. Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд эрсдэлийн дүн шинжилгээг хийж, хяналтаас чөлөөлөх саналыг боловсруулна. 3. Гадаад худалдаа эрхлэгчдэд хууль тогтоомжийг сурталчлах, зохион байгуулах чиглэлээр Олон нийттэй харьцах албатай хамтран байгууллагын вэб хуудсаар зөвлөмж, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна. 5. Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй “Хилийн хяналт удирдлагын систем”-ийн хөгжүүлэлтийг кодчиллол, хөгжүүлэлт, суурилуулах, бета тест, сургалт хийх, гарын авлага бэлтгэх, хүлээлгэн өгөх тест нэвтрүүлэлт гэх мэт үе шатуудаар дуусгасан байна.</p>	<p>Аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу импортын хүнсний өндгөнд хийгдэж буй хил дээрх хяналт шалгалтыг хөнгөвчлөх, хил нэвтрэх үйл ажиллагааг түргэсгэх зорилгоор Эрсдэлийн удирдлагын хэлтэстэй хамтран ажиллаж тодорхой саналуудыг боловсруулж 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 252 тоот дотоод албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 105 дугаар тогтоолоор чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өргийн албан татвараас чөлөөлөх зорчигчийн худалдан авсан 3.0 сая хүртэл үнийн дүнтэй 546 нэр төрлийн барааны жагсаалтыг баталсан. Дээрх жагсаалтад орсон бүтээгдэхүүнд мал, амьтаны гаралтай хадгалалт, тээвэрлэлтийн онцгой нөхцөл шаарддаг мах, махан бүтээгдэхүүнүүд чөлөөт бүсүүдэд хяналт, шинжилгээгүй борлуулагдаж буй байдлыг зогсоох зорилгоор Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулан 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 196 тоот дотоод албан бичгээр Хяналт, бүрдүүлэлтийн газарт</p>	<p align="center">2025.01.01 2025.06.10</p>	<p align="center">100</p>
-------------------------	--	---	---	---	---	---	---------------------------

			<p>Дээрх ажлын хэсэг нь ОХУ-аас экспортлох хүсэлт гаргасан 22 аж ахуйн нэгж БНХАУ-аас хүнсний өндөг импортлох хүсэлт гаргасан 4 ААН, Франц улсаас үржлийн үхэр импортлох хүсэлт гаргасан 1 ААН-ийн хүсэлтийг тус тус хянан танилцуулга боловсруулж холбогдох нэгжийн даргаар хянуулж ХХААХҮ-ийн сайдад танилцуулж шийдвэрлүүлсэн.</p>		<p>хүргүүлсэн. “Мах, махан бүтээгдэхүүний экспорт ба импортлогч орны шаардлага”-сэдвээр контент болон богино видео бичлэг бэлтгэн Гаалийн байгууллагын мэдээллийн хэрэгслээр түгээж ажилласан.</p> <p>Хүрсэн үр дүн: Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний хорио цээр, аюулгүй байдлын шаардага тодорхой болж Аж ахуй нэгж, иргэдэд мэдээлэл нээлттэй болсон.</p>		
--	--	--	---	--	--	--	--

Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх

7	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>"Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-д санал өгч ажилласан. Хэлтсийн удирдлагаас өгөгдсөн үүргийн дагуу УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд боловсруулан тайлагнаж ажилласан.</p>	<p>1.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулж ажиллан, илэрсэн зөрчил дутагдалд дүн шинжилгээ хийнэ. 2.ГЕГ-ын даргын 2019 оны 275 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг шинэчлэхэд хорио цээрийн чиглэлэр саналыг өгч ажиллана. 3. Хорио цээрийн чиглэлээр хөрш зэргэлдээ болон бусад улсын мэргэжлийн байгууллагатай санамж бичиг, протоколыг байгуулахад санал өгч ажиллана. 3. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн</p>	<p>Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын шинэчилсэн төсөлд санал боловсруулан тогтоосон хугацаанд өгсөн. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан МУ-ын ЗГ-ын 173 дугаар тогтоолын1,2,3 дугаар хавсралтуудыг шинэчлэн төслийг боловсруулсан. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн</p>	2025.01.01 2025.06.10	100
---	---	-------------------------	---	---	--	--------------------------	-----

			<p>хорио цээрийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан ЗГ-ын тогтоолоор батлуулах 4 журам, зааврын төслийг боловсруулах.</p> <p>4. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтын дагуу “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих тусгай шаардлага, тээврийн хэрэгсэлд хийгдэх халдваргүйжүүлэлтийн журам”-ыг боловсруулж, батлуулна.</p> <p>5.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.</p>	<p>хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэгт заасан амьтны гоц халдварт өвчин болон ургамлын хорио цээртэй хөнөөлт организм улсын хилээр нэвтрэн тархах эрсдэл үүссэн болон үүсч болзошгүй нөхцөл байдал бүрдсэн үед баримтлах нийтлэг журам /дэглэм/-ийг боловсруулан ажиллаж байна.</p> <p>Хөдөө аж ахуйн ерөнхий хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг танилцуулах” хэлэлцүүлэгт оролцож Хилийн хорио цээрийн хяналт үйл ажиллагааны мэдээлэл өгч санал өгч ажилласан.</p> <p>2025 оны 05 дугаар сарын 28- ны өдөр Хорио цээрийн цахим системээс “Импортын гэрчилгээ”-г олгох болсонтой холбогдуулан Тэмдэгтийн хураамж авах, төлбөр, тооцоог цахим сувгуудыг ашиглан хялбараар төлөх гарцуудыг нээх асуудлын хүрээнд Интерактив ХХК-ын төлөөлөл, МТГ болон СХОГ-ын дарга, улсын байцаагчидтай уулзалт зохион байгуулж шийдлийг танилцуулж шийдвэрлэсэн.</p> <p>Хорио цээрийн цахим систем дэх Импортын мэдэгдэл бүртгэх, импортын гэрчилгээг цахимаар олгох модульд 3 удаа тест хийж сайжруулалтын саналуудыг боловсруулж өгсөн.</p> <p>Импортын гэрчилгээний</p>	
--	--	--	--	---	--

					хүснэгтийг нөхөн бичих зааврыг боловсруулсан. Хүрсэн үр дүн: Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд хийгдэх хорио цээрийн хяналтын эрх зүйн зохицуулалт тодорхой болсон.		
8	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Удирдлагын шуурхай хуралдаанаас өгсөн 3 үүрэг даалгавар, 1 зөвлөмж, онлайн хурлын 1 үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажилласан.	1. Хэлтсийн ажлын мэдээг 7 хоног, сар, жилээр төлөвлөн тайлагнаж ажиллана. 2. СЭРП программын “Үүрэг даалгавар” цэс дээр байршуулсан хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж ажиллана. 3. Өргөдөл, гомдлыг хугацаанд нь хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.	Ажлын мэдээг 7 хоног, сар улирлаар төлөвлөн тайлагнаж ажилласан. Байгууллагын удирдлагууд болон хэлтсийн дарга, ахлах байцаагчаас өгөгдсөн үүрэг, даалгавруудыг цаг тухай бүрт нь биелүүлж тайлагнаж ажилласан. Хүрсэн үр дүн: Үүрэг даалгавар биелэгдсэн	2025.01.01 2025.06.10	100
9	Үндсэн шалгуурт тусгагдаагүй цаг үеийн шинжтэй бусад ажлыг төлөвлөх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Хийж гүйцэтгэсэн байна.	1.ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодтой хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг уялдуулж ажиллана. 2.МУ-ын УИХ-ын захирамж, холбогдох тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэсгүүдэд ажиллана. 3.Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээний хүрээнд төрийн болон төрийн бус болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллана.	“Монголын махны холбоо” ТББ-ын төлөөллүүдтэй ГЕГ-ын ХБГ, ХЦХ-ийн хамтарсан уулзалтыг 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, МУ-аас сэврээсэн мах экспортлох үеийн хорио цээр, гаалийн хяналт, хөнгөвчлөх асуудлаар санал солилцож ажилласан. МЭЕГ-ын удирдлагуудтай 2025 оны 01 дүгээр сарын 08, 01 дүгээр сарын 22-ны өдрүүдэд Дэд даргын түвшний хүрээнд уулзалт хийж, экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийн шилжүүлэлтийн асуудлаар санал солилцож, 2025.02.20-ны өдрөөс МЭЕГ албан ёсоор гэрчилгээ, мэдэгдлийг хүлээн авахаар хурлын шийдвэрийг гаргуулсан	2025.01.01 2025.06.10	100

					ХХААХҮЯ-ны салбарын хяналтын газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж Импортын хүнсний аюулгүй байдал, хяналт шалгалтын талаар санал солилцсон. “Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ГХЯ, НҮБ-ын АНДЭЗНК болон ЕХ-ны Монголын гадаад худалдааг дэмжих төсөлтэй хамтран 3 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд Монголын цахим худалдааны долоо хоног арга хэмжээнд 2 өдрийн сургалтад хамрагдсан. Хүрсэн үр дүн: Төрийн болон төрийн бус байгууллагуудтай мэдээлэл солилцоо сайжирч хяналт шалгалтын зохион байгуулалт сайжирсан.		
10	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Ажлын цаг ашиглалтыг 100 хувь ханган ажилласан.	Ажлын цаг ашиглалтыг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	Тасалсан өдөргүй, бүтээмжтэй ажилласан.	2025.01.01 2025.06.10	100
ХОЁР. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ТЖАХ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан биелэлтийг ханган ажилласан.	1.ТЖАХ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан биелэлтийг ханган ажилласан байна. /I-II улирал/	ТЖАХ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын болон нэгжийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан. Төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнаж ажилласан.	2025.01.01 2025.06.10	100

2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, ажилласан.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, ажилласан байна.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу 2024 онд үйлдсэн баримт, бичгүүдийг архивын нэгж үүсгэн хүлээлгэж өгсөн. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд 2024 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж мэдүүлсэн.	2025.01.01 2025.06.10	100
---	--	-------------------------	---	--	---	--------------------------	-----


ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

НЭГ. "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1	Арга хэмжээ "Гаалийн хорио цээрийн ГУБ нарын мэргэшүүлэх сургалт"-ад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Гаалийн хэргийн мэдлэг олгох сургалтад хамрагдах	Гаалийн хэргийн мэдлэг дээшилсэн	2025.01.01 2025.06.10	100
---	--	-------------------------	--	----------------------------------	--------------------------	-----

ТАЙЛАН ГАРГАСАН:

МАЛ ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ
(албан тушаал)

Г.ШҮРЭНЧУЛУУН /  /
(нэр, гарын үсэг)

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ
ӨДӨР
(огноо)

**ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Г.ШҮРЭНЧУЛУУНЫ 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
Нэгжийн нэр: ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТЭС

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулдаг үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх					
1	Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх	59	8	67	
Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах					
1	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах	58	8	66	
2	Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын хэрэгжилт	59	8	67	
3	Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл, экспортлогч улсын мал эмнэлэг, ариун цэвэр, ургамлын хорио цээрийн гэрчилгээг үндэслэн импортын гэрчилгээ олгох үйл ажиллагаанд хяналт тавих	58	8	66	
4	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	58	9	67	
5	Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд хяналт тавих	59	8	67	
Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх					
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	58	9	67	
2	Үүрэг даалгаврын биелэлт	60	10	70	
3	Үндсэн шалгуурт тусгагдаагүй цаг үеийн шинжтэй бусад ажлыг төлөвлөх	60	10	70	
4	Ажлын цаг ашиглалт	59	8	67	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1	Гаалийн хэргийн мэдлэг олгох сургалтад хамрагдах	100	15	
Дундаж оноо:			15	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1	Хандлага, ёс зүй	6	
2	Дүн шинжилгээ хийх	7	
3	Асуудал шийдвэрлэх	6	
4	Хариуцлагатай байдал	6	
5	Ажлын цаг ашиглалт	7	
Дундаж оноо:		7	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1	Хандлага, ёс зүй	7.7
2	Багаар ажиллах	7.8
3	Харилцаа	7.7
Дундаж оноо:		7.6

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	61.8
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7.6
5	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо =		91.4

(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт, мэдлэг, ур чадварын үнэлгээ)

чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) -
Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо +
Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:
ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

.....(Г.БАТМӨНХ)

2025.06.10 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

.....(Г.ШҮРЭНЧУЛУУН)

2025.06.10 (огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

.....(Г.ЭНХТАЙВАН)

2025.06.25 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

.....(Ө.ТЭГШЭЭ)

2025.06.25 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

.....(Р.ОТГОНЖАРГАЛ)

2025.06.15 (огноо)